



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/144

Сүхбаатар сум

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж,
иргэдийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 3.1, аймгийн Онцгой комиссын 19 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтэд хурдацтай тархаж байгаа /COVID-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор замын хөдөлгөөний болон нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн болон замын хөдөлгөөн хязгаарлах, тусгаарлах байруудын аюулгүй байдлыг хангахад зориулан хамгаалалтын хашлага хийхэд шаардагдах 4.985.000 /дөрвөн сая есөн зуун наян таван мянга/ төгрөгийн дэмжлэгийг аймгийн Цагдаагийн газарт үзүүлсүгэй.

2. Хамгаалалтын хашлага хийхэд шаардагдах 4.985.000 /дөрвөн сая есөн зуун наян таван мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.


3. Зардлын тайланг 2020 оны 06 дугаар сарын 15-ны дотор гаргаж тайлагнахыг Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа /А.Энхбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш ОРГИЛ



Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 05 -р сарын 14 -ны
өдрийн А/144 дугаар захирамжийн
хавсралт



Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн хөдөлгөөнийг
хязгаарлах хамгаалалтад шаардагдах хашлаганы төсөв

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Тайлбар
1	Труба /ф25мм/	метр	7.4	5500	40700	Нэг хашлага хийхэд шаардагдах материал
2	Труба /ф15мм/	метр	15	3600	54000	
3	Гагнуурын электрод	ш	10	500	5000	
	Дүн				99700	
	50 ширхэг хашлага хийлгэхэд				4.985.000	

Төсвийн тооцоо гаргасан:
ХЭЗХ-ийн ахлах мэргэжилтэн

Л.Баярсүрэн

Хянасан:
АЗДТГ-ын тооцооны нягтлан бодогч

Ц.Уранцэцэг